

ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА ЖАМЬЯНСЭНГЭЭГИЙН ЭРДЭНЭБОЛДЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн түвшин			
					Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь	
Зорилт: 1. “Улсын хилээр хууль бус бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх”								
1	Гаалийн зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт	Хэрэгжил, гүйцэтгэлээр, хувиар	-	<ul style="list-style-type: none"> - Нийт зөрчлийн тоо, торгуулийн дүн, нөхөн төлүүлсэн гаалийн болон 	<ul style="list-style-type: none"> - Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2306 зөрчил илрүүлж 5093.5 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 3511.4 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулж, 18.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 3026.6 сая төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна. Үүнээс: <ul style="list-style-type: none"> - 2209 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, 4678.2 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 3277.1 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. - 42 зөрчлийн хэрэг бүртгэлт хийж, 415.3 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 234.2 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. - 55 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. <p>Нийт зөрчлийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.1 хувиар ёссэн, нөхөн төлүүлсэн татварын дүн 6.28 хувиар буурсан, торгуулийн дүн 1.29 хувиар ёссэн үзүүлэлттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - АТГ-аас зөрчил гаргах шалтгаан нөхцлийг арилгах, арга хэмжээ, сургалт зохион байгуулах тухай 4 мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах, үр дүнг тооцож хариу хүргүүлэх чиглэлийг газрын ГУАБ-д өгч удирдлагаар ханган ажилласан. - Тагнуулын ерөнхий газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн бөхөнгийн эвэртэй холбоотой зөрчил, - СБД дэх цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн согтууруулах ундааны зүйл худалдан борлуулсан гэх зөрчил, - Эрүүгийн цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн эм зөвлөгийн хэрэгсэлтэй холбоотой зөрчил, - НХХААГ-аас харьяаллын дагуу шилжиж ирсэн хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой 2 зөрчил, 	100	2024.01.01 2024.12.10	

					- Эрүүл мэндийн яамнаас харьяаллын дагуу шилжик ирсэн эмнэлгийн багаж төхөөрөмжтэй холбоотой 1 зөрчлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. - Замын-Үүд боомтоор 2023 онд улсын хилээр нэвтэрсэн ачааны тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгах тухай ГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн удирдамжийн дагуу Замын-Үүд боомтоор 2023 онд улсын хилээр орсон тээврийн хэрэгслийн бүртгэлийг КАЙС програмд хүчингүй төлөвт шилжүүлсэн, тээврийн хэрэгслийг бүртгэлгүй нэвтрүүлсэн зөрчлийг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйгээр хангаж, чиглэл өгч ажилласан.			
2	Гаалийн зөрчлөөс урьдчилан	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлсэн байна. 2. Зөрчилд ихээр өртөгдсөн бараа, эд зүйлс, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж болзошгүй, эрдэлтэй бараа, эд зүйлсийн судалгааг хийж, холбогдох мэдээлэл, эрх зүйн зохицуулалтын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сээрэмжлүүлнэ. 3. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын мэдлэг	Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд харьяа гаалийн газар хороодод 14 албан бичгээр холбогдох чиглэлийг хүргүүлж, урьдчилан сэргийлэх танхимын болон цахим 19 удаагийн сургалтыг нийт 890 гаруй албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, гаалийн зөрчил болон холбогдох бусад 9 мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар түгээх ажлуудад хяналт тавьж удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Үүнд: - ГЕГ-ын ОНХА-тай хамтран Гаалийн ерөнхий газрын www.customs.gov.mn цахим хуудсанд "Бусдын дайвар ачаа авахаас татгалзах" тухай сээрэмжлүүлэг, "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх улсын хилээр бэлэн мөнгө (валют)-ийг нэвтрүүлэхэд анхаарах" асуудлын талаар сээрэмжлүүлэг мэдээ бэлтгэн хүргүүлэхэд, - Монголын Үндэсний олон нийтийн телевизитэй хамтран хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихдоо бусдаас дайвар ачаа авахгүй байх тухайн дайвар ачаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, МУ-ын эмийн жагсаалтад бүртгэлгүй эм, тариа зэрэг хориглосон, хязгаарласан бараа байгаа тохиопдолд тухайн хүн өөрөө хуулийн хариуцлага хүлээх тухай анхааруулга мэдээллийг "Цагийн хурд" мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүргэхэд, - ДГБ-ын Бүс нутгийн зөрчлийн мэдээлэл солилцох төв (RILO)-өөс Зөрчлийн мэдээллийн сүлжээ (CEN)-ээр ирүүлсэн Ази номхон далайн бус нутгийн гаалийн байгууллагуудын 2023 онд илрүүлсэн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараатай холбоотой 2023 оны зөрчлийн мэдээллийн зурагт танилцуулгыг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэхэд,	Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд харьяа гаалийн газар хороодод 14 албан бичгээр холбогдох чиглэлийг хүргүүлж, урьдчилан сэргийлэх танхимын болон цахим 19 удаагийн сургалтыг нийт 890 гаруй албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, гаалийн зөрчил болон холбогдох бусад 9 мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар түгээх ажлуудад хяналт тавьж удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Үүнд: - ГЕГ-ын ОНХА-тай хамтран Гаалийн ерөнхий газрын www.customs.gov.mn цахим хуудсанд "Бусдын дайвар ачаа авахаас татгалзах" тухай сээрэмжлүүлэг, "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх улсын хилээр бэлэн мөнгө (валют)-ийг нэвтрүүлэхэд анхаарах" асуудлын талаар сээрэмжлүүлэг мэдээ бэлтгэн хүргүүлэхэд, - Монголын Үндэсний олон нийтийн телевизитэй хамтран хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихдоо бусдаас дайвар ачаа авахгүй байх тухайн дайвар ачаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, МУ-ын эмийн жагсаалтад бүртгэлгүй эм, тариа зэрэг хориглосон, хязгаарласан бараа байгаа тохиопдолд тухайн хүн өөрөө хуулийн хариуцлага хүлээх тухай анхааруулга мэдээллийг "Цагийн хурд" мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүргэхэд, - ДГБ-ын Бүс нутгийн зөрчлийн мэдээлэл солилцох төв (RILO)-өөс Зөрчлийн мэдээллийн сүлжээ (CEN)-ээр ирүүлсэн Ази номхон далайн бус нутгийн гаалийн байгууллагуудын 2023 онд илрүүлсэн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараатай холбоотой 2023 оны зөрчлийн мэдээллийн зурагт танилцуулгыг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэхэд,	2024.01.01 2024.12.10	100
	сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ							

				чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна.	<ul style="list-style-type: none"> - ДГБ-ын Ази номхон далайн бүс нутгийн Зөрчлийн мэдээлэл солилцох төв /RILO/-еэс ирүүлсэн цуврал Сээрэмжлүүлэг мэдээлэл /20 удаагийн/ орчуулж, дотоод сүлжээгээр /СПАРК/ харьяа гаалийн газар хороодод хүргүүлэхэд, - Улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэх зөрчил, гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх зөрчилд холбогдсон бараа, эд зүйлсийн судалгаа, дүн шинжилгээг сүүлийн 3 жилийн байдлаар хийж, судалгааны дунг албан хаагчдад танилцуулж мэдээллээр хангах, гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сээрэмжлүүлэг, мэдээллийг гаалийн харилцаанд оролцогчдод түгээх, сурталчлан таниулах ажил зохион байгуулахад, - Газар хороодод 19 удаагийн чиглэл хүргүүлэхэд, - Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, галт зэвсгийн сум, салютыг санамсар болгоомжгүй байдлаар биедээ болон эд зүйлдээ авч явснаар гэмт хэрэг, зөрчилд холбогдож, хуулийн хариуцлага хүлээх эрсдэлтэй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурагт танилцуулга, мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар түгээхэд, - Олон улсын валютын сангаас 4 дүгээр сарын 8-наас 10-ны өдрүүдэд гаалийн байгууллагад зохион байгуулсан "Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэт арга техник" сэдэвт сургалт зохион байгуулахад, - Мөн 4 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд харьяа гаалийн газар, хороодын зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан албан хаагчид болон тус газрын албан хаагчдыг хамруулсан уулзалт сургалтыг зохион байгуулахад. - ГЕГ-ын даргын баталсан удирдамжын дагуу ГЕГ-ын чиглэл хариуцсан нэгжийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр БЦТ, УБГГ, ЧХОУНБГГ, УХШИГГ, СЭГГ, ДаГГ-дад ажиллаж, тус газруудтай холбоотой ААН, иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дунд суурилсан үйл ажиллагаа, улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэхтэй тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх, гомдол мэдээллийн шийдвэрлэлт болон төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж ажиллах чиглэлээр гаалийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажлыг албан хаагчдад танилцуулж, холбогдох мэдээ, мэдээллийг хүргэсэн. 		
3	Гадаад, дотоодын байгууллагууд тай хамтран	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	- Гадаад, дотоодын хууль сахиулах байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, харьяа	<ul style="list-style-type: none"> - Япон улсын Токио хотод 2024 оны 2 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгууллагдсан Дэлхийн гаалийн байгууллагын Ази, номхон далайн орнуудын өндөр түвшний уулзалтад ГЕГ-ын дарга Р.Отгонжаргалын хамт оролцож, Эрсдлийн удирдлага ба зөрчлийн мэдээллийн дун 		

	ажилласан байдал		гаалийн газар, хороодыг мэдээллээр хангаж ажилласан байна - Хууль хяналтын бусад байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажилласанаар зөрчил илрүүлсэн байна.	шинжилгээ, Зерчлийн мэдээлэл солилцох бус нутгийн хамрах хүрээг өргөтгөх, Гаалийн байгууллага хооронд солилцох зөрчлийн мэдээлэл ба сүүлийн үеийн чиг хандлага, Хил дээр хууль сахиулахад ашиглах дэвшилтэт технологийн судалгаа, Далай тэнгисийн худалдаа тээвэр ба усан онгоцны эрдлийн удирдлага, Хууль бус худалдаатай тэмцэх мэдээллийн анализик сэдвүүдээр ярилцлага хийж холбогдох мэдээллийг авсан. - Дараах сургалт, хууль сахиулах ажиллагаанд газрын албан хаагчдыг хамруулж, удирдлага мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Үүнд: - ДГБ-ын Хууль сахиулах хорооны 2024.03.18-ноос 22-ны өдрүүдэд цахим хэлбэрээр явагдсан 44 дүгээр хурал, - "Хуурамч барааны хууль бус эргэлттэй тэмцэх, оюуны өмчийн эрхийг зөрчиж болзошгүй хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй бусад төрлийн хууль бус бараа эргэлтийг таслан зогсоох, тэдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх". хууль сахиулах ажиллагаа, - Тайланд Улсын Бангкок хотноо 4 дүгээр сарын 22-оос 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ДГБ-ын "Синтетик төрлийн хар тамхины ОУ-ын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх санаачлага" арга хэмжээ, - АНУ-ын Эл Пасо хотноо 4 дүгээр сарын 08-аас 12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Хилийн аюулгүй байдал, төмөр замын зорчигч, ачаа тээврийн үзлэг шалгалт" сургалт, - БНХАУ-ын Шанхай хотноо 2024 оны 07 дугаар сарын 02-ноос 04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Аюултай хог хаягдлын хил дамнасан хууль бус эргэлттэй тэмцэх Олон улсын "хууль сахиулах ажиллагаа, - Бүгд Найрамдах Индонез Улсын Денпасар (Бали) хотноо 2024 оны 09 дүгээр сарын 02-ноос 06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ДГБ-ын "Синтетик төрлийн хар тамхины ОУ-ын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх санаачлага" 2 дахь арга хэмжээ, - Тайланд Улсын Бангкок хотноо 2024 оны 09 дүгээр сарын 09-нөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан	2024.01.01 2024.12.10	100
--	------------------	--	---	---	--------------------------	-----

					<p>“ силлагааны холбоо баригч албан хаагч нар оролцсон Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлзуулахад хяналт тавих тухай базелийн конвенцын Цахилгаан, электроник тоног төхөөрөмжийн (Цахим) хог хаягдал (e-waste)-тай холбоотой нэмэлт өөрчлөлтийн талаар сургалт,</p> <ul style="list-style-type: none"> - БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын Хууль бус наймаатай тэмцэх газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас хамтран Шанхай хотноо 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалт, - Тайландын хаант улсад Европын аюулгүй байдлын зөвлөлөөс 11 дүгээр сарын 04-нөөс 08-ны өдрүүдэд зохион байгуулсан Хар тамхи, тарифийн бус хязгаарлалттай бараа, аюултай хог хаягдлын чиглэлээр сургалт. <p>- ГХАХ-ээр дамжуулан дараах санал, хүсэлтүүдийг уламжилсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын ГХЯ хоорондын Консулын XI зөвлөлдөх уулзалттай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай” 1998 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хэлэлцээрийн 13 дугаар зүйл “Туршлага солилцох”-ийн 2.b-д заасан “гаалийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалт”-ны дагуу тус улсын стратегийн барааны экспортын хяналт, үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд ашиглаж болзошгүй (хоёрдмөл зориулалт бүхий) барааны гаалийн хяналт, хууль бус бараа эргэлтийг илрүүлэх талаар туршлага солилцох сургалтад гаалийн ажилтнуудыг хамруулах боломжтой эсэх талаар санал, - ДГБ-ын Хууль сахиулах хорооноос Стратегийн (хоёрдмөл зориулалттай) бараа Худалдааны Хяналтыг Хэрэгжүүлэх чиглэлээр өөрийн гишүүн орнуудад техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Стратегийн барааны Худалдааны Хяналтыг Хэрэгжүүлэх тухай 2023 онд шинэчлэн гаргасан гарын авлагыг орчуулан гаалийн улсын байцаагч нарын хүртээл болгож өгөх хүсэлт, 		
--	--	--	--	--	--	--	--

				<ul style="list-style-type: none"> - "БНХАУ-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин ОХУ руу гарсан барааны дагалдах бичиг баримтыг хуулбарлан авах хүсэлт бүхий" ОХУ-ын ХГА-ны 2024 оны оот албан хүсэлтийн хариу, - Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусlamжийн хүрээнд КОЙКА хамтын ажиллагааны байгууллагын шугамаар 2026 онд хэрэгжүүлэх тусlamжийн тесөлд гаалийн байгууллагын Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм, бусад хориглосон барааг илрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, барааг хууль бусаар хил нэвтрүүлэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаалийн хяналт шалгалтын сүүлийн үеийн "3D X-Ray baggage scanner" тоног төхөөрөмжийг тусlamжаар авах хүсэлт. 	
				<ul style="list-style-type: none"> - Хууль сахиулах чиглэлээр хил орчмын бүс нутагт хамтран ажиллах асуудлаар МҮ-ын ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газар, ОХУ-ын Холбооны гаалийн албаны Контрабандтай тэмцэх ерөнхий газрын харьяа Сибирь болон Алс дорнодын бүсийн гаалийн хууль сахиулах газруудын ажлын долдугаар уулзалтыг 6 дугаар сарын 10-аас 12-ны өдрүүдэд зохион байгуулж, ОХУ-ын Красноярск хотноо 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдөр болсон ажлын 6 дугаар уулзалтын протоколын дагуу хийгдсэн ажлуудыг дүгнэн хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэж, хамтын ажиллагааг цаашид шинэ шатанд хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон. - Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс хооронд 2024 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх, таслан зогсоо чиглэлд хамтран ажиллах төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. - Өнгөрсөн онд Тагнуул, Цагдаа, Гаалийн байгууллагын дарга нарын хамтран баталсан "► хамтарсан арга хэмжээний үд дүнгийн хэлэлцүүлгийг 3 дугаар сарын 14-ний өдөр ГЕГ-т зохион байгуулж "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис", "Түүх соёлын дурсгалт зүйлс", "Алт"-ыг Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчил, гэмт хэргийн онцлог, гэмт этгээдүүдийн ашиглаж буй арга хэлбэр, хилийн хяналтын байгууллагуудын хэрэгжүүлж буй хяналт, шалгалтад үнэлэлт, дүгнэлт хийж цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээ, харилцан мэдээлэл 	

					<p>солилцох хамтын ажиллагааны талаар хэлэлцэж, хамтарсан ажиллагааны удирдамж боловсруулж батлуулахаар тохиролцсон. Уг арга хэмжээний нэгдсэн санал, дүгнэлтийг ГЕГ-ын даргад танилцуулсан ба арга хэмжээг зохион байгуулах ажлын төвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна.</p> <p>- Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монгол шуудан ХК 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хамтран ажиллах санамж бичгийг байгуулах ажилд оролцсон.</p>		
4	Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоотой гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоотой гомдол мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна.	<p>"Иргээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, албан бичгээр ирсэн 16 өргөдөл, 15 гомдол, 18001281 утсанд ирсэн 8 мэдээлэл, 4 гомдол, ЗГ-ын 1111 утсанд ирсэн 2 мэдээллийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж ажилласан байна.</p>	2024.01.01 2024.12.10	100
5	Зөрчлийн мэдээллийн санд хяналт тавьсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	<p>- CAIS систем дэх гаалийн зөрчлийн мэдээллийн санд хяналт тавьсан байна,</p> <p>- Мэдээлэл дун шинжилгээ, боловсруулалт хийж илрүүлсэн зөрчлийн тоог өмнөх оныхоос 3 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.</p>	<p>- Харьяа гаалийн газар, хороодын эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлж буй хойшлуулшгүй ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах, гаалийн байгууллагын цахим системийн зөрчлийн мэдээллийн санд оруулсан бүртгэл, мэдээллийг хянах, илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх танилцуулгыг түргэн шуурхай авч мэдээллийг түргэн шуурхай хүргэж байх ажлыг удирдлагаар ханган ажилласан.</p> <p>- Мэдээ, тайланг гаргаж холбогдох нэгжид хүргэх ажилд хяналт тавьж байсан.</p> <p>- Харьяа гаалийн газар, хороодод хийгдэж буй гаалийн бүрдүүлэлтэд эрсдэл тооцож, татвараас зайлсхийх зөрчилд хийсэн судалгаа, дун шинжилгээнд тулгуурлан гаалийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх, улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын хүрээнд газрын албан хаагчдад чиглэл өгч ажилласнаар 2024 оны эхний 11 сарын байдлаар "гааль зөвшөөрөв" төлөvt 36 удаагийн дахин шалгалтыг зохион байгуулж, үр дүнг ирүүлэх ажлын чиглэлийг өгч ажилласнаар гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн 31 зөрчил илрүүлж 291.5 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 145.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.</p> <p>- Шуурхай хяналтын төвийн үйл ажиллагаанд чиглэл зөвлөмж өгч удирдлагаар хангаж ажилласнаар тус төвөөс</p>	2024.01.01 2024.12.10	100

					харьяа гаалийн газар, хороодын гаалийн бүрдүүлэлтэд Телехяналтын нэгдсэн систем ашиглан, батлагдсан онилгооны шалгуураар Таблью дата аналитик платформд сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож 54 зөвлөмжийг бичиг баримт, хяналт шалгалтын үе шатанд илгээнээр 40 бүрдүүлэлтэд буюу 74.07 хувьд нь зөрчил илэрч, 218.6 сая төгрөгийн татварыг нөхөн телүүлж, 109.2 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна.		
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"

1	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Зөрчилтэй тэмцэх чиглэлээрх эрх зүйн акт, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг тухай бүр холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	<p>- "Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө"-ний улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх зорилтын хүрээнд "Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д 2 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.3, 2.4 дүгээр ажлын түйцэтгэлийг эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргахад хяналт тавьж ажилласан.</p> <p>- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний доорх төлөвлөгөөнүүдэд гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх саналыг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • "Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлээр • "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлээр • "Гаалийн ерөнхий газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2024 оны төлөвлөгөө" <p>- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2023 оны төлөвлөгөөний биелэлт, тайлан"-г хүргүүлж 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн.</p> <p>- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд дараах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний биелэлтүүдийг хүргүүлсэн.</p> <p>- Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гарган дотоод зурvasaар ЗУГ-т хүргүүлсэн.</p>	100
2	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	-Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль,	<p>- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт Гаалийн байгууллагыг төлөвлөн орж дээрх хуулийн шинэчилсэн найруулгын төсөлийг боловсруулах, энэ хүрээнд</p>	

				Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна	дагаж мөрдөгдөх болон бусад эрх зүйн зохицуулалтыг судалж, холбогдох саналыг хүргүүлсэн. - Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллага, Тагнуулын ерөнхий газар, Нийслэлийн прокурорын газар, Захиргааны хэргийн шүүх, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Оюуны өмчийн газраас ирүүлсэн нийт 423 албан бичгийн хариуг Зөрчлийн тухай жууль бөлөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд бэлтгэн хугацаанд нь хүргүүлсэн байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар холбогдох баримтуудыг нотлох баримтын шаардлага хангулан хүргүүлэхэд, - “Иргэдээс териин байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг шийдвэрлэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, 45 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч шийдвэрлэхэд, - ГЕГ-ын ЗББНДБ-аас хуулийн төслийн шинэчлэсэн найруулага, үйл ажиллагааны заавар, журам, төлөвлөгөө болон төслиүүдэд санал ирүүлэх тухай 47 удаагийн дотоод зурvasын хариуд тус нэгжээс тусгах саналыг хүргүүлэхэд, - Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 06 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “ГЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн А/123 дугаар “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан бүтцийн дагуу тус газрын дарга, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, харьяа гаалийн газар, хороодын зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан нэгжийн дарга, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч болон харьяа газар хороодын дарга нарын албан тушаалын тодорхойлолтод оруулах өөрчлөлтийг боловсруулж, захиргааны удирдлагын газарт хүргүүлэхэд тус тус удирдлагаар ханган ажилласан.	2024.01.01 2024.12.10	100
3	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн эрсдлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн байна	ГЕГ-ын даргын 2024 оны “Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар тус газар нь дарга, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч 4, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй газрын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сүүлийн 3 жилд тус газарт тогтвортой ажиллаж байгаа 2 албан хаагч, бусад албан хаагчид 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар ажиллаж, 2 албан хаагч өөр нэгжид шилжин ажилласан байна.		

					ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн иугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бүтцээр гаалийн улсын байцаагчийн орон тоо байгаа боловч 2024 онд гаалийн улсын байцааг ажилласан. Иймд тус нэгийн "Үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль бус барааны эргэлт, худалдааны луйвар, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хэрэгжүүлэх" үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болох хүний нөөцийн эрсдэлийг тогтоож, албан хаагчдын тогтвортой, мэргэшсэн байдал, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хүний нөөцийн эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Тухайлбал:	2024.01.01 2024.12.10	100
					<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын мэргэшсэн, чадварлаг байдал, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах шаардлагын хүрээнд зохих хууль тогтоомжид нэмж тусгуулах саналыг боловсруулан ХЗДХ-ийн сайдад 5 дугаар сарын 27 ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн. - Сул орон тоог нөхөх зорилгоор харьяа гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэжлийн индекс, тавигдах бусад шаардлагыг хангах албан хаагчийн судалгаа явуулж, 1 албан хаагчийн мэдээллийг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн боловч татгалзсан хариу ирүүлсэн. - Мэдээлэл дүн шинжилгээ, боловсруулалт хийж, удирдлагыг шийдвэр гаргах мэдээллээр хангах зорилгын хүрээнд шинээр батлагдах албан тушаалын тодорхойлолтын теселдтус чиглэлийн мэргэжлийн индексийг тусгасан санал хүргүүлсэн. 		
4	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	<ul style="list-style-type: none"> - Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу ажил зохион 	<p>Тайлант хугацаанд Захиргааны удирдлагын газраас 4, Эрсдлийн удирдлагын хэлтсээс 1, Сургалтын төвөөс 4 үүрэг даалгавар, ХШҮДАГ-аас 13 зөвлөмж, Онлайн хурлын 1 даалгавар, Ёс зүйн дэд хорооны 1 даалгавар ирүүлснээс холбогдох арга хэмжээг зохион байгуулан биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх чиглэлийг албан хаагчдад өгч удирдлагаар ханган ажилласан.</p> <p>- Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн хүрээнд нийт 22 удаагийн чиглэлийг албан бичгээр хүргүүлж, үр дүнг тооцон, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна.</p>	2024.01.01 2024.12.10	100

				байгуулах чиглэл өгч удирдлагаар хангаж ажилласан байна, - ГЕГ-аас Харья гаалийн газар хороодод өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж , чиглэлийн дагуу хийгдсэн ажлуудыг дүгнэж, биелэлтийг хангулж ажилласан байна			
5	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна.	Хөдөлмерийн дотоод журмын дагуу нэгжийн бүх албан хаагч цаг бүртгэлийн нүүр таних тохиромжид бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай үед гадуур ажиллах тохиолдолд СЕРП-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. Нэгжийн чиг үүргийн онцлогоос хамаарч алба хаагчид илүү цаагаар, гар утасны бэлэн байдлыг 24/7 цагаар ханган ажиллаж байна.	2024.01.01 2024.12.10	100
6	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	- Хууль хяналтын байгууллага болон иргэдээс ирүүлсэн албан бичиг, лавлагаа, мэдээллийг хугацаанд нь боловсруулсан байна - Харья гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна.	"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж нийт 1217 албан бичиг, 31 өргөдөл, гомдол ирсэнийг хүлээн авч шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж, удирдлагаар ханган ажилласан. - "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эрзэлтэд хяналт тавих тухай хууль"-ийг шинчлэн боловсруулж батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, гаалийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх чиглэлд санал хүргүүлсэн. - ГЕГ-ын даргын баталсан удирдамжын дагуу ГЕГ-ын чиглэл хариуцсан нэгжийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр БЦТ, УБГ, ЧХОУНБГГ, УХШИГГ, СЭГГ, ДагГ-дад ажиллаж, тус газруудтай холбоотой ААН, иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дунд суурилсан үйл ажиллагаа, улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэхтэй тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх, гомдол мэдээллийн шийдвэрлэлт болон төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж ажиллах чиглэлээр гаалийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажлыг албан хаагчдад танилцуулж, холбогдох мэдээ, мэдээллийг хүргэсэн. - Нийслэлийн прокурорын газраас ЗГ-ын 2021 оны 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Шийтгэлийн	2024.01.01 2024.12.10	100


					болов шийтгэлээс чөлөөлөх хуудасны маят, хэрэглэх журам"-ыг зарим эрх бүхий байгууллага нэг мөр хэрэгжүүлж ажиллахгүй байгаа тул шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилон ажиллуулах, шийтгэлийн хуудсыг олгосон тооцоо, зарцуулалтын тайлант гаргаж хэвших, сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажиллах тухай 01 дүгээр сарын 05-ны өдрийн гаартай албан бичгийн дагуу холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч хариуг хүргүүлсэн. - Орхон, Булган аймаг дахь хууль хяналтын байгууллагуудын хамтран зохион байгуулсан "Тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагчдыг чадавхуулах хамтарсан сургалт, зөвлөгөөн"-д оролцсон. - Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах бүрэлдэхүүн, удирдах ажилтны зөвлөгөөн"-д оролцсон.		
					- Харьяа гаалийн газар хороодод албан томилолтоор ажиллах тохиолдолд ГЕГ-ын бүтцийн нэгжүүдээс тухайн гаалийн газар хороонд хүргүүлэх чиглэл, бусад шаардлагатай ажил арга хэмжээг давхар хэрэгжүүлэх үүднээс бүтцийн нэгжүүдээс санал авсан ба Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас Орхон аймаг дахь гаалийн газарт 2023 онд хийгдсэн дотоод аудитын хүрээнд хүргүүлсэн зөвлөмжийн турван ажлын биелэлтийг бодит байдалтай нийцэж буйг шалгуулах саналыг 2024 оны 09 дүгээр сарын 12- ны өдрийн гаартай дотоод зурвасаар ирүүлсэн. Үүний хүрээнд Орхон аймаг дахь гаалийн газарт ажиллах хугацаанд дотоод зурваст дурдсан ажил арга хэмжээний дагуу бодит байдалтай танилцаж, шаардлагатай танилцуулга, мэдээллийг авсан ба Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт мэдээллийг хүргүүлсэн.		
7	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөни й хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХАСХӨМ-ыг хуулийн хугацаанд, үнэн зөв бөглөж, тайлагнасан. Гаалийн байгууллагын Авлигын эсрэг төлөвлөгөөг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, гаалийн байгууллагын үйл ажиллагаа, хийгдэж буй цахим, техник технологи шинэчлэлт, гарч буй үр дүнгийн талаарх 27 удаагийн мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар олон нийтэд түгээсэн.	2024.01.01 2024.12.10	100

Хоёр. Мэдлэг чадвараа хөгжүүлэх зорилтын хүрээнд

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	ОУВС-аас зохион байгуулсан "Менгэ угаах гэмт хэргийг мөрдөн шалгах дэвшилтэй арга, техник" сургалтыг амжилттай зохион байгуулж оролцсон.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	-	Сургалтыг бодит кейс дээр суурилсан практик дасгал хэлбэрээр асуудлыг шалган шийдвэрлэх арга зүйд суурилан явуулснаараа бусад сургалтаас онцлог болсон.	2024.01.01-2024.12.10	100
2	"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт Гаалийн байгууллагыг төлөөлөн орж дээрх хуулийн шинэчлэн найруулгын төсөлийг боловсруулах ажилд оролцож, гаалийн байгууллагад хамаарах саналыг хүргүүлж, энэ хүрээнд дагаж мөрдөгдөх болон бусад эрх зүйн зохицуулалтыг судалж, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	-	"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт Гаалийн байгууллагыг төлөөлөн орж дээрх хуулийн шинэчлэн найруулгын төсөлийг боловсруулах ажилд оролцож, гаалийн байгууллагад хамаарах саналыг хүргүүлж, энэ хүрээнд дагаж мөрдөгдөх болон бусад эрх зүйн зохицуулалтыг судалж, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна	2024.01.01-2024.12.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Зөрчилтэй тэмцэх газрын дарга



/ Ж.Эрдэнэболд / 2024. 12. 00.

ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА Ж.ЭРДЭНЭБОЛДЫН 2024 ОНЫ АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Зөрчилтэй тэмцэх газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		63,98

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөл, Сахилгын хорооны гишүүний хувиар холбогдох хууль, журмын мэдлэгээ судалж, дээшлүүлэх		12,5
2	Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтад хамрагдах		12,5
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			12,5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	14
2	Удирдан зохион байгуулах	13,5
3	Асуудал шийдвэрлэх	13
4	Манлайлах	13
5	Багаар ажиллах	12,5
6	Харилцаа	14
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	—
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15,33

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	63,98
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний	12,5

	биелэлт	
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13,53
	Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	89,8

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч

(Р. Отгонжаргал)
2024.12.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Зөрчилтэй тэмцэх газрын дарга

Нэгжийн дарга:

(Ж.Эрдэнэболд)
2024.12.20 (огноо)